

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2019 оны 08 сарын 07-ны өдөр**

Тендер шалгаруулалтын нэр: **“Дизель түлш” нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/201904561**

**“Монголросцветмет” ТӨҮГ** эрх бүхий тендерт оролцогчдоос **“Дизелийн түлш”** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэгүй авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000.00 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **2017, 2018 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт санал болгосон үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.**

Туршлага: **Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 100%-иас багагүй хэмжээний ижил төстэй бараа, ажил, үйлчилгээг сүүлийн 2 жилд дор хаяж нэг удаа гүйцэтгэсэн байна.**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: **Шаардлагатай**

Тендерийн хамт 4,006,000 төгрөгийн тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг **2019 оны 09 дугаар сарын 10 -ны өдрийн 10:00 цагаас** өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба **мөн өдрийн 10:05 цагт** цахим системээр нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрнө.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно:

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 405 тоот өрөө, утас: 450060 + 118

**“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ**